



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2011 оны 11 сарын 04 өдөр

Дугаар 40

Улаанбаатар хот


Шагналын журам батлах тухай


Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйл, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12 дахь заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналын төрөл, түүнийг олгох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тогтоолыг 2012 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3 Шагналыг хэвлүүлэх болон дагалдах мөнгөн шагналд шаардагдах зардлыг тооцож Хурлын 2012 оны төсөвт тусгуулах талаар арга хэмжээ авч ажиллахыг Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Т.Баясгалан/-д даалгасугай.

ДАРГА  Д.БАТБИЛЭГ



Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 11 дугаар
сарын 07 -ны өдрийн 40 дугаар тогтоолын
хавсралт

ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ШАГНАЛЫН ТӨРӨЛ, ТҮҮНИЙГ ОЛГОХ ЖУРАМ

Дүүргийн ИТХ-ын Төлөөлөгчид, ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын алба, Засаг даргын Тамгын газрын болон Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын ажилтнууд, байгууллага, хамт олон, аж ахуйн нэгж, иргэд, сонгуультнуудын үйл ажиллагааг идэвхжүүлж, ажлыг нь дүгнэж шагнахад энэхүү журмын зорилго оршино.

ШАГНАЛЫН ТӨРӨЛ

Нэг. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагнал

1.1 Хан-Уул дүүргийн ИТХ-ын “Хүндэт өргөмжлөл”-өөр дүүргийн тэргүүний байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүнийг шагнана. “Хүндэт өргөмжлөл”-ийг 40000 /дөчин мянган/ төгрөг дагалдана.

1.2 Хан-Уул дүүргийн ИТХ-ын “Хүндэт үнэмлэх”-ээр дүүргийн ИТХ-ын Төлөөлөгч, төр захиргааны тэргүүний ажилтан, сонгуультан, идэвхтэн, иргэдийг шагнана. “Хүндэт үнэмлэх”-ийг 30000 /гучин мянган/ төгрөг дагалдана.

Хоёр. Шагналд нэр дэвшүүлэх, олгох журам

2.1. Дүүргийн ИТХ-ын шагналд дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчид, Төлөөлөгчид, Хурлын Ажлын алба, дүүргийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс албад, байгууллага, аж ахуйн нэгж нэр дэвшүүлж тодорхойлолтоо ирүүлнэ.

2.2. Шагнуулах хүмүүсийн ажил байдлын тодорхойлолт, анкет, хамт олны хурлын тэмдэглэл, өргөн мэдүүлсэн албан бичиг болон холбогдох материалыг дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба хүлээн авч, бичиг баримтын бүрдэл, шагнуулах үндэслэл, тодорхойлолтыг хянан үзэж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад танилцуулж шийдвэрлүүлнэ.

2.3. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын захирамжаар шагнал олгох асуудлыг шийдвэрлэх бөгөөд Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж байна.

2.4. Шагналын дагалдах мөнгөний хэмжээ инфляцийн түвшин, төсвийн хөрөнгө зэргээс шалтгаалан өөрчлөгдөж болно.

2.5. Шагналыг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн баяр ёслол болон байгууллага, аж ахуйн нэгжийн ойн баярыг тохиолдуулан гардуулна.